



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 02 сарын 08 өдөр

Дугаар 1/82

Алтай хот

“Туульсын хаан Жангар” арга  
хэмжээнд хөрөнгө гаргах тухай”

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 10, 11 дүгээр тогтоол, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 07 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нэгдсэн Үндэстний Байгууллагын боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага буюу Юнеско-д 2009 онд бүртгэгдсэн Монгол тууль, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн А/759 дугаар тушаалаар батлагдсан Монгол Улсын яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өв болох Монгол Жангар хайлах өвийг хамгаалах, сурталчлах, өвлүүлэх, “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.4 дэх зорилгыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зохион байгуулагдах “Туульсын хаан Жангар” арга хэмжээний урьдчилсан бэлтгэл ажилд шаардагдах 8,535,000 (найман сая таван зуун гучин таван мянга) төгрөгийг хавсралтаар баталж, аймгийн Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

2.Захирамжийн хэрэгжилтийг хангаж, хөрөнгийн зарцуулалтыг тайлагнан ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилт, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ), Нийгмийн бодлогын хэлтэс (С.Мөнхжаргал)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2023 оны  
 38 дугаар сарын 08-ны өдрийн 18 дугаар  
 захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

2023.01.20.

№		Үйл ажиллагаа	Шаардлагатай зүйлс	Хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Тайлбар
<b>ТУУЛЬ ХАЙЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УРЬДЧИЛСАН БЭЛТГЭЛ АЖИЛД ШААРДАГДАХ ЗАРДАЛ</b>							
/Ажлын хэсэг/							
1		Сумдэд арга зүйн зөвлөгөө өгөх	Шатахууны зардал	-	-	1,000,000	-
2		"Жангар" уран зураг зуруулах	"Эзэн богд Жангар"-ын хөрөг	1 ш	1,000,000	1,000,000	-
			"Өнчин Жангар"-ын хөрөг	1 ш	1,000,000	1,000,000	-
3		Жангарын эмхэтгэл хийлгэх	Баринталласан эмхэтгэл	100ш	10,000	1,000,000	-
4		Зочид төлөөлөгчдийг байршуулах зардал	-	5	-	1,350,000	-
				<b>ДҮН: 5,350,000</b>			
<b>ХҮНДЭТГЭЛИЙН ИДЭЭ, ХЭРЭГЛЭГДЭХҮҮН</b>							
15		Ёслолын идээ, ундаа бэлдэх	Хорхой ааруул	3кг	28,000	84,000	
16			Идээ	1ш	300,000	300,000	
17			Хоормог	10л	7,000	70,000	
18			Арц	5кг	20,000	100,000	
19			Ганга	5кг	20,000	100,000	
20			Цэвэр ус	1,500ш	1,000	1,500,000	
21			Нэг удаагийн аяга	40 боодол	5,500	220,000	
				<b>ДҮН: 2,374,000</b>			

Есөнбулаг

Д/д	Бараа, материалын нэр	Тос, хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт дүн
1	Арц	3 кг	45.000	135.000
2	Ганга	3 кг	40.000	120.000
3	Хурганы арьс	3ш	35.000	105.000
4	Мод	8 шуудай	7.500	60.000
5	Шар тос	3 кг	32.000	96.000
6	Хонины хормойтой өвчүү	5 кг	9.000	45.000
7	Бусад			250.000
Нийт				<b>811.000</b>
НИЙТ ТӨСӨВ:8,535,000				